ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорнод аймгийн Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/104/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ЗТХС | Зам Тээвэр Хөгжлийн Сайд |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| БСШУСЯ | Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам |

## Агуулга

Аудитын гэрчилгээ ....2
Аудитын тайлан....4
2.1. Оршил ....4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт....5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин....5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар....6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..8
2.12. Шилэн дансны мэдээлэл ....8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга....8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....8
Менежментийн захидал....9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ....10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан....12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....13

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 162

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
П.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баян-уул сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорнод аймгийн Баян-уул сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Баян-уул сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

110520084

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч П.Оюунцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Уул сумын Соёлын төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дотоод болон гадаадын соёлын чиг үүрэгт хамаарах асуудлаар адил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагатай, мөн өөрийн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, ардын авъяастнуудтай хамтран ажиллах ба тэдэнд урлагийн талаар арга зүйн зөвлөмж, сургалт явуулж, үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээг нэмэгдүүлэх”-д оршино.

Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Иргэд, ардын авьяастны дунд тэдний хэрэгцээ, сонирхолд түшиглэн соёл-чөлөөт цагийн олон талт ажлыг зохион байгуулах
- Байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, ардын авьяастныг түшиглэн үндэсний уламжлалт болон хүүхдэд зориулсан урлаг, сонгодог урлагийг сурталчлан дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах чиглэлээр сургалт явуулж, хамтлаг, хэсэг зохион байгуулан хүн амын соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх
- Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баян-Уул сүмын Соёлын төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Баян-Уул сумын Соёлын төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Баян-Уул сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 37 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 75,420.9 мянган төгрөгөөс тооцон 1,508.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,602.2 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 48,290.8 | 55,329.3 | 7,038.5 |
| Үндсэн хөрөнгө | 441,884.7 | 442,116.5 | 231.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | (40,366.1) | (56,238.6) | (15,872.5) |
| **Нийт хөрөнгө** | **449,809.4** | **441,207.2** | **(8,602.2)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 449,809.4 | 441,207.2 | (8,602.2) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **449,809.4** | **441,207.2** | **(8,602.2)** |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь урлагын хувцас хэрэглэлд шинэчлэл хийх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6,059.5 мянган төгрөгийн урлагын хувцас, 250.0 мянган төгрөгийн бүжгийн малгай, БСШУСЯ-аас 140.5 мянган

төгрөгийн ном, 576.5 мянган төгрөгийн багц ном хандиваар хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд бичиг хэргийн 12,751.8 мянган, аж ахуйн 42,577.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 231.8 мян төгрөгөөр Принтер авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 441,207.22 мянган төгрөг болж 8,602.21 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 75,420.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 75,420.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 74,557.7 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байна.

Баян-Уул сумын Соёлын төв 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансанд өөрийн үйл ажиллагааны 2,031.8 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс 231.8 мянган төгрөгөөр принтер, соёл урлагын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 37 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6,419.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,346.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,072.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 4,346.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Тайлант хугацаанд гарсан зардлаас 4,346.3 мянган төгрөгийн зардлыг ибаримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015

“татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллалаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 2,031.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

1. Кассын тайлан, билетийн тооцоо зэрэг бэлэн мөнгөний баримтуудын иж бүрнээр нь бэлтгэж байх. Орлогын эх үүсвэрийг тодорхой хөтлөн бүртгэлд тусгах.
2. Соёлын төв өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон жишиг НБББББ-г ашиглан боловсруулж санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Баян-Уул сумын Соёлын төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Уул сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь  нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналт

1.1 Илрүүлэлт: Тулгалтаар 2031,8 мян төгрөгийн орлогыг СҮДТ-нд нэмэлт санхүүжилт үзүүлэлтэд 231,8, Үндсэн үйл ажиллагааны орлого 1800,0 мян төгрөгийн хуваарилж бичсэн байна. Мөн үндсэн санхүүжилтийн харилцах дансанд орлогоо шилжүүлсэн байна.

1.2 Эрсдэл: Нэмэлт санхүүжилтийн данс ашиглаагүй нь Төсвийн тухай хуулийг зөрчиж байна.

1.3 Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн дансаар өөрийн орлогыг төвлөрүүлж шилжүүлж байх

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 40.9  мянган төгрөгийн зөрүүтэй байсан.

2.2. Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтанд ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,290,832.00** | **55,329,335.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,290,832.00 | 55,329,335.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,290,832.00 | 55,329,335.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 12,022,809.00 | 12,751,812.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,268,023.00 | 42,577,523.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **401,518,594.81** | **385,877,886.29** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 401,518,594.81 | 385,877,886.29 |
| **392** | **Биет хөрөнгө** | 383,088,594.81 | 367,447,886.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 359,810,379.05 | 359,810,379.05 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (8,294,999.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 27,690,319.00 | 27,922,119.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (23,554,829.24) | (26,903,625.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,505,829.24 | 29,505,829.24 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,405,033.32) | (16,203,866.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,448,200.00 | 6,448,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,406,269.92) | (4,836,149.88) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,430,000.00 | 18,430,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,430,000.00 | 18,430,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **449,809,426.81** | **441,207,221.29** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **449,809,426.81** | **441,207,221.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 449,809,426.81 | 441,207,221.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 249,909,401.24 | 249,909,401.24 |
| 51101 | Өмч: - төрийн | 231,479,401.24 | 231,479,401.24 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 18,430,000.00 | 18,430,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 199,814,545.57 | 191,212,340.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 199,814,545.57 | 199,814,545.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (8,602,205.52) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 85,480.00 | 85,480.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **449,809,426.81** | **441,207,221.29** |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **283,301,090.00** | **84,229,203.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **224,337,320.00** | **8,576,503.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 8,576,503.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,000.00 | 8,576,503.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,800,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,000,000.00 | 6,776,503.00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 223,337,320.00 | - |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 223,337,320.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **58,963,770.00** | **75,652,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 56,304,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 56,304,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,658,870.00 | 231,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,358,870.00 | 231,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 75,420,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 75,420,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **78,460,814.48** | **92,831,408.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **78,460,814.48** | **92,831,408.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 73,125,712.48 | 90,168,224.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 36,258,700.00 | 52,518,030.30 |
| 210101 | Үндсэн цалин | 32,418,700.00 | 37,626,321.26 |
| 210102 | Нэмэгдэл | 480,000.00 | 938,953.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,360,000.00 | 13,952,756.04 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,350,300.00 | 6,672,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,900,201.00 | 4,537,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 317,828.00 | 427,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 274,474.00 | 507,215.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 132,748.00 | 133,385.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 725,049.00 | 1,067,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,374,868.00 | 11,850,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,757,608.00 | 1,530,348.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,617,260.00 | 10,319,652.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,145,044.00 | 888,286.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 81,400.00 | 178,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 214,720.00 | 149,986.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 100,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 79,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 174,680.00 | 379,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,374,244.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | 200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 250,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 250,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,504,000.00 | 1,416,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,504,000.00 | 1,256,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,242,800.48 | 16,122,508.52 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,000.00 | 250,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,122,800.48 | 15,872,508.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,335,102.00 | 2,663,183.70 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,320,400.00 | 1,799,960.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,320,400.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,799,960.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,702.00 | 863,223.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,702.00 | 863,223.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **204,840,275.52** | **- 8,602,205.52** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 27,126,790.58 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.24 | - |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 27,126,790.34 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - 27,126,790.58 | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **177,713,484.94** | **- 8,602,205.52** |

## 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **58,963,770.00** | **77,452,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **1,800,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,800,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 1,800,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,800,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **58,963,770.00** | **75,652,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 56,304,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 56,304,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,658,870.00 | 231,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,358,870.00 | 231,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 75,420,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 75,420,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **58,963,770.00** | **77,452,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **58,963,770.00** | **77,452,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **53,628,668.00** | **74,789,516.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 36,258,700.00 | 52,518,030.30 |
| 210101 | Үндсэн цалин | 32,418,700.00 | 37,626,321.26 |
| 210102 | Нэмэгдэл | 480,000.00 | 938,953.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,360,000.00 | 13,952,756.04 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,350,300.00 | 6,672,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,900,267.00 | 4,537,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 356,286.00 | 427,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 296,408.00 | 507,215.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 72,522.00 | 133,385.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 724,817.00 | 1,067,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,374,868.00 | 11,850,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,757,608.00 | 1,530,348.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,617,260.00 | 10,319,652.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 770,800.00 | 907,086.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 81,400.00 | 197,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 214,720.00 | 149,986.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 100,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 79,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 174,680.00 | 379,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 250,000.00 | 731,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 231,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 250,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,504,000.00 | 1,660,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,344,000.00 | 1,500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 120,000.00 | 250,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,000.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,335,102.00** | **2,663,183.70** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,320,400.00 | 1,799,960.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,320,400.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,799,960.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,702.00 | 863,223.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,702.00 | 863,223.70 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 249,909,401.24 | 85,480.00 | 199,814,545.57 | - | 449,809,426.81 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **249,909,401.24** | **85,480.00** | **199,814,545.57** | - | **449,809,426.81** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **249,909,401.24** | **85,480.00** | **199,814,545.57** | - | **449,809,426.81** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **249,909,401.24** | **85,480.00** | **199,814,545.57** | - | **449,809,426.81** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **249,909,401.24** | **85,480.00** | **199,814,545.57** | - | **449,809,426.81** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (8,602,205.52) | - | (8,602,205.52) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **249,909,401.24** | **85,480.00** | **191,212,340.05** | - | **441,207,221.29** |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 77,220,900.00 | 76,357,676.30 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 77,220,900.00 | 76,357,676.30 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 75,420,900.00 | 74,557,716.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 53,380,600.00 | 52,518,030.30 |
| 210101 | Үндсэн цалин | 39,532,600.00 | 37,626,321.26 |
| 210102 | Нэмэгдэл | - | 938,953.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,848,000.00 | 13,952,756.04 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,672,600.00 | 6,672,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,537,400.00 | 4,537,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 427,000.00 | 427,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 533,800.00 | 507,215.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 106,800.00 | 133,385.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,067,600.00 | 1,067,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,850,000.00 | 11,850,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,000,000.00 | 1,530,348.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,500,000.00 | 10,319,652.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 907,700.00 | 907,086.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 197,700.00 | 197,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,000.00 | 149,986.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 100,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 80,000.00 | 79,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 380,000.00 | 379,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | 200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,660,000.00 | 1,660,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 250,000.00 | 250,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,800,000.00 | 1,799,960.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,800,000.00 | 1,799,960.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,799,960.00 |